



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 743

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 15 нэрийн, нийт 4,110,811,861.00 (дөрвөн тэрбум нэг зуун арван сая найман зуун арван нэгэн мянга найман зуун жаран нэг) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Зам, тээврийн яамны (Замын сан) хөрөнгийн холбогдох дансанд (капиталжуулан) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132003099

31-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
743 дугаар тогтоолын хавсралт

ЗАМ,ТЭЭВРИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД КАПИТАЛЖУУЛАН БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, хаяг	Замын дугаар	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замын 80 км-т Ногоон довын даваанд амрах талбай-зогсоол	A0201	285,663,461.00	285,663,461.00
2	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замын 181 км-т 90-ийн овооны орчимд амрах талбай-зогсоол	A0202	328,815,661.00	328,815,661.00
3	Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замын 112 км амрах талбай-зогсоол	A0301	352,326,154.00	352,326,154.00
4	Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замын 326 км Л.Пүрэвдоржийн гэрэлт хөшөө орчимд амрах талбай-зогсоол	A0301	297,603,618.00	297,603,618.00
5	Алтай -Ховд чиглэлийн авто замын Баарангийн даваа орчимд амрах талбай-зогсоол	A0304	197,544,996.00	197,544,996.00
6	Баянхонгор-Алтай чиглэлийн авто замын 73 км орчимд амрах талбай-зогсоол	A0303	247,832,806.00	247,832,806.00
7	Дархан-Эрдэнэт чиглэлийн авто замын 104-105 км Зараагийн хөндий орчимд амрах талбай-зогсоол	A1001	246,045,105.00	246,045,105.00
8	Булган-Мөрөн чиглэлийн авто замын 194 км Тариалан сумын салдаг уулзвар орчимд амрах талбай-зогсоол	A0902	220,953,677.00	220,953,677.00

Д/д	Хөрөнгийн нэр, хаяг	Замын дугаар	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
9	Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн авто замын 171 км Замчдын овоо орчимд амрах талбай-зогсоол	A0501	129,364,046.00	129,364,046.00
10	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын 266,3 км Чулуут уулын орчимд амрах талбай-зогсоол	A0502	328,067,408.00	328,067,408.00
11	Өндөрхаан-Баруун-урт чиглэлийн авто замын 89 км амрах талбай-зогсоол	A2001	208,942,210.00	208,942,210.00
12	Лүн-Дашинчилэн-Ихтамир чиглэлийн авто замын 233 км Хар бухын балгас орчимд амрах талбай-зогсоол	A27	220,420,334.00	220,420,334.00
13	Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замын 85-105 км орчимд амрах талбай-зогсоол	A0603	315,940,773.00	315,940,773.00
14	Мөрөн – Улиастай чиглэлийн авто замын 385.3 км орчимд амрах талбай-зогсоол	A1102	445,660,311.00	445,660,311.00
15	Нөмрөг-Сонгино-Наранбулаг-Улаангом чиглэлийн авто замын Улаанбаатар талаас 330-332 км орчимд амрах талбай-зогсоол	A18	285,631,301.00	285,631,301.00
			4,110,811,861.00	4,110,811,861.00
	Нийт дүн			(дөрвөн тэрбум нэг зуун арван сая найман зуун арван нэгэн мянга найман зуун жаран нэг)

